

ТҮРЭГ, МОНГОЛ УГСААТНЫ ОВОГ-АЙМАГ, ЭЗЭНТ УЛС, ИХ ГҮРНИЙ НЭРИЙТГЭЛ (V-XV ЗУУН): ГАРАЛ ҮҮСЛИЙН ТҮҮХЭН ҮНДЭС, БЭЛГЭДЭЛ - УТГА ЗҮЙН ЗАРИМ АСУУДАЛ

Б.Напил*

Товч агуулга: Угсаатны нэрийтгэл, түүний үгийн гарал, бэлгэдэл, утга зүй болон нэрлэх, нэрлэгдэх зэрэг угсаатны нэр зүйн түүх-соёлын судалгааны асуудал хүрээнд түрэг, монгол угсаатны V-XV зууны түрэг, монгол бичгийн сурвалжуудын үндсэнд тулгуурлан зарим нэрийтгэлийн үгийн гарал, бүтэц, бэлгэдэл, утга зүй болон эртний сэргээлтийг, зарим шинэ таамаглал дэвшүүлэн гаргахыг хичээсэн болно. Тухайлбал, **Oq+uz> oq* – (сум, нум сум), + *uz* (олон тооны утгалбар) *ок+уз*, **Törü+k> Törü* + («төрт засагт төр хуульт улс») + *k* (улс, иргэн олон), **Qoy+qur>*oyqur> Uyur* > «хойд зүгийн + махчин шувуу», монгол: *qoyidu>хойд зүг*, **Yay+man> yaу->* «нум, нум татагч, нумчин», 2. мон: *Nauman>nuumin>* (*numin*?) нум, нумч, **Kerey> 1.* «махчин шувуу, махчин жигүүртэн», 2. *qarya>* карга «хэрээ», 3. мон: *Keriy-e> хэрээ*, **Qir+qir> qir+qiz>* «Махчин жигүүртэн», **Yaq+lay+ayir> *Yal+ayir> 1.yaq>* йак «саадаг, нум сум», мон: *saγadaγ>саадаг*, 2. *yal>* йал «дэл, дэлт адуу», 3. *yaq+laqar>* йаклакар-«тос, тос түрхэх» (?) ; **Berkin>Merkit > 1.* мэргэн нумч, 2. нум сум, нумч, 3. зэв; **Moŋγol > 1.* **moŋγūn->* «мөнгөн», 2. **morinγin> moŋγul->* морь, морин, морилох, монгол (?), 3. түрэг: *bōŋk->* буйлах, эмнэг туйлах, *mōŋkū->* ардаг догшин морь (?), **meŋγūr-> meŋγūl->* менгүр, монгор, монгол (?) зэрэг болно.

Түрэг, монгол угсаатны нэрийтгэлд нүүдлийн соёл иргэншлийн оюуны (Тэнгэрийн шүтлэг, домгийн, бэлгэдлийн зэрэг) болон материаллаг (байгалийн юмс үзэгдлийн, ан амьтны, нийгмийн харилцааны, морьтон нүүдлийн аж ахуйн, зэр зэвсгийн, тамга тэмдэг зэргийн) баялагтай шууд уялдаа, холбоотой оноосон нэр, нэрийтгэл түгээмэл тохиолдож байгаа бөгөөд тэдний нэрийдэх гарлын эхлэл, хувиран өөрчлөгдөх, өвөрмөц болон

* Казахстан улс, Астана хот. Олон улсын Түрэг академийн ахлах шинжээч. napilbaz@gmail.com

нийтлэг хэрэглээ нь овог, аймаг, улс - төрийн тогтолцоо, бүтэцтэй хамааралтай хэдий ч эртний нэрийтгэлээ удаан хугацаанд хадгалагдах явц нь бас байгаа болно. Одоо хүртэл тухайн нэгэн овог, аймаг, улс гүрний нэрийтгэлийн талаар нэгэн мөр санал, баттай нотолгоотой судалгаа дутагдсаар байгаа билээ.

Түлхүүр үг: Түрэг угсаатан, монгол угсаатан, овог, аймаг, аймгийн холбоо, угсаатны нэр зүй, угсаатны нэрийтгэл, этноним, үгийн гарал зүй, бэлгэдэл, утга зүй, бичгийн эх сурвалж.

Удиртгал.

Түрэг, монгол угсаатны нэрийтгэл болон тэдний яс, овог, аймаг, ханлиг, хаант улс, эзэнт гүрэн зэрэг цэрэг-улс төрт засаглалын бүрэлдэхүүн хэсгүүдийн тухай V-XV зууны түүхэн эх сурвалжууд нь түрэг, монгол, манж, нанхиад, төвөд, согд, перс, араб, герек зэрэг өрнө-дорно дахины олон хэлээр янз янзаар галиглан, элдэв бүрээр «аялгуулан» тэмдэглэж ирсэн, бас ч «хочлон, дооглон» бичсэн ч байдаг бөгөөд уг түрэг, монгол угсаатны нэрийтгэл, этнонимийн гарал, утга зүйн талаар тун ч хомсхон мэдээлэл үлдээсэн байдаг билээ. Учир иймд, дундад зууны эриний (тухайлбал V - XV зууны) түрэг, монгол угсаатны овог-аймаг, улс, гүрний нэрийтгэлийн түүхэн харьцуулсан гарал зүйн судалгаа нь их талын морьтон нүүдэлчдийн түүхэн харилцаа холбооны учир утгыг шинжлэн тодруулахад чухал салбарын нэг болой. Эртний түүхэн бичгийн эх сурвалжуудыг нягтлан түрэг, монгол угсаатны зарим нэрийтгэлийн гарал, үүсэл, бэлгэдэл, утга зүйн зарим асуудлыг энд хөндөж, өөрсдийн саналаа толилуулан байгаа билээ.

Судалгааны арга зүй

Эртний түүхийн, ялангуяа бичгийн эх сурвалжуудад тулгуурлан түрэг, монгол угсаатны овог-аймгийн нэрийтгэлийн олон хэлний эх хувилбарыг харьцуулан, тэдгээрийг угсаатны соёлын онцлогийг болон гарал зүйг, утга зүй, бэлгэдэл зүйг харгалзан, түүхэн харьцуулсан сэргээлт хийх арга зүйг голлон хэрэглэсэн болно.

Хам (синхрон) цагийн түрэг, монгол угсаатны нэрийтгэлийн гарлыг, цуваа (диахрон) цагийн үүднээс нэрийтгэл зүйн¹ хууль жамын бодит

¹ Тухайлбал, нэр судлал («ономастиология»), нэрийтгэл зүй («ономастика»), оноосон нэр («оним»), угсаатны нэр зүй («этнонимика»), «угсаатны өөрийн нэр» (эндоэтноним), угсаатны газрын нэр («этнотопоним»), «улс-төрийн нэрийтгэл» (политоним), «хүний нэр» («антропоним»), домгийн нэр («мифоним»), газар нутгийн нэр судлал («топонимика»), усны нэр (гол, мөрөн, нуур зэрэг, усан гадаргын нэр, «гидроним»), газрын гүдгэр, хотгор хэлбэрийн нэр (уул нуруу, толгод, хөндий жалга зэрэг, «ороним»), суурин газрын нэр («ойконим»), хөдөөний айлын нэр («комоним»), хотын нэр («астоним»), ургамлын нэр («фитоним»), од эрхэсийн нэр зүй («космонимика»), амьтны нэр зүй («зоонимика»), арьс өнгөний нэр («макроэтноним»), «нийгмийн нэр» («соционим») зэрэг өргөн хүрээтэй судалгааны их талбар бий.

байдлыг анхааран, угсаатны нэрийтгэлд өгдөг бэлгэдэл зүй, тэдгээрийн хувьсал, өөрчлөлт, түүхэн улбаат залгамжит мөн чанарыг тодорхойлох, нүүдэлчдийн тамгатай цогц тогтолцооны нэрийтгэлийн утга зүй болон улсын цэрэг-улс төрийн засаглалын (төв, зүүн, баруун жигүүр), үндсэн бүтцийн (овог, аймаг, ханлиг, хаант улс, эзэнт гүрэн) овог, аймаг, ханлиг, улс төрийн эвслийн нэгдэх, төвлөрөх, салан тусгаарлагдах, холдон ангижрах зэрэг олон талыг харьцуулан судлах арга зүйг боловсруулан судлах шаардлагатай ч байгаа билээ.

Судалгааны хэсэг
Түрэг, монгол угсаатны нэрийтгэлийн (этнонимийн)
түүх-соёлын утга-бэлгэдлийн үндэс

Түүхэн бичгийн эх сурвалжуудад тохиолдох түрэг, монгол угсаатны нэрийтгэл (этноним, этнополитоним) буюу яс, овог, аймгийн нэрсийн онцлог, тэдгээрийн янз бүрээр тэмдэглэгдэх, хэрэглэгдэх явц, авиа зүй-авиалбар зүйн, нутгийн аялгууны тэмдэглэл, угсаатны бэлгэдэл зүйн болон гарвал зүйн (тотемын, домгийн, үлгэр - домгийн, аман ярианы зэрэг) хүрээнд түүхэн-эх сурвалжийн үүднээс харгалзан үзэх хэрэгтэй маш өргөн хүрээг хамарсан ээдрээтэй асуудал байдаг билээ.

Ер санаваас, түрэг, монгол угсаатны нэрийтгэлийн (этнонимийн) талаар нэгэн сэдэвт судалгааны дорвитой бүтээл тун ч ховор бөгөөд ихэвчлэн шинжилгээний өгүүлэл төдийгөөр л хязгаарлагдсан байдгийг дурдах байна. Зарим судлаачдыг дурдваас, түрэг нэрийтгэлийн тухайд Н.А.Аристов, Ю.А.Зуев (Зуев, 1960; Зуев, 1969), Clauson G. (Clauson, 1963), Кузеев (Кузеев, 1974), Т.И. Султанов (Султанов, 1977), Н.А.Баскаков (Баскаков, 1980), В.У.Махпиров (Махпиров, 1997), О.Каратаев (Каратаев, 2003) зэрэг, мөнхүү монгол нэрийтгэлийн тухайд Х.Пэрлээ (Пэрлээ, 1976), Г.Сүхбаатар, Л.Билэгт, Б.Батсүрэн, Ц.Шагдарсүрэн, Элдэнтэй, Ардаажав, А.Очир (Очир, Сэржээ, 1998; Очир, 2016) зэрэг олон судлаачдыг онцлон дурдаж болно.

Бид энд түүхэн - харьцуулсан судалгааны зарим үр дүнгээ хүснэгтлэн үзүүлэхийг зорилоо. Тухайн угсаатны нэгэн нэрийтгэлийн тухай эх сурвалж, судалгааны талаар дэлгэрэнгүй тайлбарлахад энэхүү өгүүллийн хэмжээ багтаамж нь боломжгүй болой.

ТҮРЭГ УГСААТНЫ ЗАРИМ НЭРИЙТГЭЛ

№	Гарал үүслийн бүтэц, [* - эртний сэргээлтийн хэлбэр]	Эртний түрэг бичгийн сурвалж (V-X)	Дундад зууны түрэг сурвалж (XI-XV)	Утга-бэлгэдэл (орчуулга) [(?)- таамаглал, магадлал ихтэй таамаг]	Гадаад эх сурвалж
1.	*Oq+uz> oq – (сум, нум сум), + uz (олон тооны утгалбар)	<u>Oyuz</u>	Огуз, Огур	Огуз- сум, сумтай, зэв, зэвтэй, сумнууд,	араб: гуз, хятад: ху (?), хуву+лу?
2.		Segiz Oyuz	-	Найман Огуз	-
3.		Toquz Oyuz	-	Есөн Огуз	-
4.		Üç Oyuz	-	Гурван Огуз	-
5.		On oq	-	Арван сум(тан)	-
6.	*Törü+k> Törü + («төрт засагт төр хуульт улс»)+ k (улс)	Türük	Türük	төрт, хууль цаазат, <u>törgü</u> > төрү төр, төр цаазат	хятад: тукюе туцзюэ тужио; мон: <u>Türüg>Түрэг</u>
7.	*Kök Türük>	Kök Türük	-	1.Көк (орд)-зүүн түрэг, 2.Тэнгэрлэг түрэг, Хөх Тэнгэрийн түрэг	мон: көке> хөх, 1.Тэнгэр; 2. Хөх; 3.наран зүг, зүүн зүг.
8.	*Türük+eš>	Türükes Türükeš	Türügeš	түрэгийн ижилтэн, түргэш	<u>хятад: туциши,</u> перс: <u>Türkman</u> > Туркман
9.	*Qara Türügeš>		-	Хар (орд)-баруун түрэг. Баруун түргэш	<u>хятад: туциши,</u>
10.	*Esi+r>	Türük Esir Türük Ešir	-	1.бүргэд, махчин шувуу; тыва, хакас: езир – «бүргэд»; 2. мон: esir >есир эвхмэл модон сандал, эзний ор суудал (?)	хятад: ашина, согд: ашинас ешир // (ашина) (<u>Р.Мөнхтулга</u>)
11.	*Tegrek>	Tegrek	Terek	мон: Terge>тэрэг, Tergen>тэргэн, гэр тэрэг, дугуйт гэр тэрэг	хятад: теле, чили, гаочэ, гаогюй гаоцзюй (<u>өндөр тэрэг-тэн</u>)
12.	* Qanq>	Qanqlī	канлы	1.Канк-канк (дугуйн чимээ). 2.канлы- том тэрэг, тэмээн тэрэг;3. мон:qangginaqu> хангинах тэрэг (?)	мон: qanlin> ханлин; хятад: канхэли, <u>динлин, гаочэ</u>
13.	*Toyula+t>	Duyulat	дуглат	«Дугуйт гэр тэрэг»	хятад: дулу
14.	*Toñi+ra>	Toñira		«Дугуйт гэр тэрэг»	хятад: тунло
15.	*Qoy+qur> [*q] oyqur> Uyur хойд зүгийн + махчин шувуу	Uyur	Уйгур	1.«хойд зүгийн жигүүртэн», 2.мон: Qoyidu>хойд зүг, хойгуур. (?)	хятад: хуй-гэ, <u>хой-ху</u>
16.		On Uyur	Уйгур	Арван уйгур	

17.	*Qurī+qan >	Qurīqan		«хойд зүгийн шувуужигүүртэн»	хятад: хулиган
18.		Üč Qurīqan		Гурван Курыкан	
19.	*Qīr+qīr> Qīr (хяргагч)+ qīz (шувуу)>	Qīrqīz	кыргыз киргиз	«Махчин жигүүртэн»	хятад: гянгунь, кяньгюй
20.	*Az>	Az	-	Аз ? («Ар?, »)	
21.	*Ček>	Ček	-	Чек ?	
22.	*Qar+luq>	Qarluq	карлук	1.«Цаст уулын жигүүртэн» , 2. Мон: Ger>гэр керлук// герлүг – гэрт, гэр бүхий, (?) 3.ирвэс мэт араатан	хятад: «гелолу, хэллолу»
23.	Üč Qarluq>	Üč Qarluq	Qarluq	Гурван карлук	
24.	*Qīp+čaq>	Qīpčaq	Кыпчак Кибчак	1. хөндий, хоосон, нүхтэй, 2. мон: хавчиг, модон сав	мон: Kibčaq, Kibčayud -Кибчагууд
25.	*Bayīrqu>	Bayīrqu	Байырку	1.баян нутаг, 2.алс холын баялаг нутаг	хятад: баегу мон: Barqužīn Töküm >Баргужин төхөм (?).
26.		Yer Bayīrqu	-	«Есөн» байырку	
27.	*Altī bay budun>	Altī bay budun	-	Зургаан баг ард олон	
28.	*Basmīl>	Basmīl	Басмыл	?	-
29.	*Čigil>	Čigil	Чигил	?	-
30.	*Čigsi >	Čigsi	Чигси	?	-
31.	*Qadar>	Qadar	Хазар	?	-
32.	*Qašar>	Qašar	Хашар	?	-
33.	*Bedi>	Bedi	Беди	?	-
34.	*Bersel>	Bersel	Берсел	?	-
35.	*Ar+qun>	Arqun Arqīn Arγīn	Arqīš Арγу Арγын	1. аргамаг хурдан хүлэг, 2. эрэгчин махчин шувуу, 3. сайн үүлдрийн адуу (?)	мон: Arulat -арулад
36.	*Yay+man>	Nayman (?)	Найман	1.түрэг: yay- йай «нум, нум татах, нумчин» 2. мон: nuymun> (numun?) нум, 3. согд: nuy+man> най- ман «нум татагч хүн» (?) 4. Nayman- Сегиз Огуз- «найман огуз» - (S.Мураяма, Л.Л.Викторова)	хятад: цзюэбу, мон: Nayman
37.	* Kerey> (махчин жигүүртэн»)	Kerey	Kereyit	1.«махчин шувуу», 2. түрэг: qarγa> карга «хэрээ», 3. мон: Keriy-e> хэрээ	мон: * Kereyit > Хэрэйд, Хэрээд

38.	*Yaq+lay+ayir> *Yal+ayir> (Нумт саадаг)	Yaqlaqar	Жалайыр	1. yaq> йак «саадаг, нум сум», мон: sayadaγ>саадаг, 2. yal> йал «дэл, дэлт адуу» 3. yaq+laqar> йаклакар «тос, тос түрхэх» (?)	мон: <i>Žalayıγ></i> Жалайыр
39.	*Qoŋ > Qoŋ+qıran > Qoŋ+γirat (махч шувуу)	-	Qoŋγirat <u>оңйрат</u> Қоңырат	1.хон хэрээ, 2. хан гарди (?), 3. мон: qun> хун шувуу, 4.мон: song+qur> шонхор	мон: Qoŋγırad> <u>Хонгарид</u>
40.	*Berkin> Berki+t > Merkit > (мэргэн)	-	Merkit <u>Мергэл</u>	1.мэргэн нумч, 2.нум сум, нумч 3. Манж: beri> нум, berken> нумаар намнах (?).	мон: Merkid> Мэргэд, _____
41.	*At+ay >	<u>Aday</u>	<u>Адай</u>	1.чоно, нохой, 2. домогийн нохой,	?
42.	*Alaš >	-	Алаш Алаша	1. alaču> алачу урц оромж, алачуг, 2. ala+š> алаг адуу, алаг морь	?
43.	*Alašin>	-	Alšin Алшын	1. alaču> алачу урц оромж, алачуг, 2. ala+š> алаг адуу, алаг морь	?
44.	*Qas+aq>	qazaq	<u>Қазак</u>	1. qas> кас «хатуу, бат бөх, хатуу төмөр» 2. Qasaγ> хасаг Тэргэний мөөрийн дугуй цагариг, 3. Qasaγ> хасаг –тулганы цагариг, 4. казгак- «приемный» -өргөмөл Қазак- «беглец», тэнүүл (В.П.Юдин)	мон: Qasaγ tergen- хасаг тэрэг (МНТ§64), Ордос: «hasaγ» -тэрэг. Буриад: «xahaγ тэргэ», Қалмақ: xasaγ tergn (grosser zweirädriger wagen)

Хүснэгт 1. Түрэг угсаатны зарим нэрийтгэл

МОНГОЛ УГСААТНЫ ЗАРИМ НЭРИЙТГЭЛ

№	Гарал үүслийн бүтэц, [<i>* - эртний сэргээлтийн хэлбэр</i>]	Эртний түрэг бичгийн сурвалж (V-X)	Дундад зууны монгол сурвалж (XI-XV)	Утга-бэлгэдэл (орчуулга, тайлбар) [<i>(?) - таамаглал, магадлал ихтэй таамаг</i>]	Гадаад эх сурвалж
1.	*Qïtañ>	Qïtañ	Кидан	1.Qïtañ> қытаң 2.Qïtan+d> Qïtad	хятад: цидань
2.	*Tatar>	Tatar	Tatar	1.Татар (?) 2.Татан	хятад: дада, тата
3.		Toγuz Tatar		Есөн татар	-
4.		Otuz Tatar		Гучин татар	-
5.			Alči-Tatar	1.« ал улаан» (?)	-
6.			Aluqai-Tatar	?	-
7.	*Tatabi>	Tatabi		?	-
8.	*Tuy+γun>	Tuyγun		түрэг: tuyγun> махчин шувуу (?)	-
9.	*Moγγol > *Moγγul >	-	Moγγol	1. *mōγγūn-> «Мөнгөн уул», 2. * mōγγūn-> «мөнгө» (Ж.Баясах), 3.*mornγin>monγun> moγγul-> морь, морин, монгол (?), 4. *meγγūn-> meγγūl-> monγun>moγγul- > менгүр, монгор, монгол (?), 5. түрэг: *böγk-> эмнэг , туйлах, догширох, Мон: Qamuq Moγγol -i Qabul-qayan meden aba. (МНТ§52)	* mōγγkū->ардаг догшин морь(?), хятад:мэнгу, монгу, менгу, перс: могол, латын: могол, манж: монго
10.		-	Qamuq Moγγol	Мон: Qamuq Moγγol -i Qabul-qayan meden aba. (МНТ§52)	-
11.	*Barqužin>	-	Barqužin Töküm	Баргу+жин төрхөм (?)	-
12.	*Qori Tüme+d>	-	Qorī Tümed	Qorī Tümed-ün 1.Хор, хоромсого 2.хори -дээд. (?)	Перс: Тумат
13.	*Qorīlar	-	Qorīlar oboy-tu	Qorīlartay Mergen	
14.	*Dörben irkin>	-	Dörben obuytan	Dörben irkin > дөрвөн иргэн мон: Dörbe> дөрөв, Dörbe+t> дөрвөд	Түрэг: Erkin> иргэн
15.	*Bayγudai >	-	Mayalıq Bayγudai	Магалиг Байагудай	перс: Баялык Баяут
16.	*Žadaran >	-	Žadaran obuytan	Bodunčar-Muṇṇaq - Žat irkin-ü kögün >Žažirada Žadaran ebüge > Žadaran obuytan, Лу.Алтын товч: Žürčidei (Жүрчидэй)	Түрэг: yat // jad -харь,өөр, холын, алсын.
17.	*Baqarin>	-	Baqarin-u ebüge Baqaridai	Baqaridai nereyitba, Baγarin-баарин	перс: баарин

18.	*Menen-Baqarin	-	Menen-Baqarin obuytan	Baqaridai-in kögün Čiduqul-Bökü. Kögün-inü mene metü törebe. Menen-Baqarin obuytan tede boluba.	казах: мең - мэнгэ
19.	*Belgünü+d	-	Belgünüd obuytan	Belgünütei Belgünüd obuytan boluba. (MHT§ 40-42)	-
20.	*Bügünü+d	-	Bügünüd obuytan	Bügünütei Bügünüd obuytan boluba.	-
21.	*Qatay+in	-	Qatayın obuytan	Buyu-Qatayı Qatayın obuytan boluba.	-
22.	*Salžiyu+t	-	Salžiyut obuytan	Buyutu-Salži Salžiyut obuytan boluba.	-
23.	*Bor+žiyin	-	Boržiyin obuytan	Bodunčar Boržiyin obuytan boluba. 1. Boržiyi+n (олон тооны дагавар) 2. Түрэг: Böri+tegin > Bōritigin > Boržiyin (чонон ханхүү?) Өвөр Монголд: Боржихон (гол)	-
24.	*Žegüreyi+d	-	Žegüreyid obuytu	Adaŋga Uriyaŋqadai Tegün-ügei бүi že, kegežü, žügeli-deče qaryažu, Žegüreyid obuytu bolyažu, Žegüred -ün ebüge tere boluba. (MHT§ 44)	-
25.	*Noyan+šiq	-	Noyaqin obuytan	Qačın-nu kögün Noyaıdai neretei бүlege. Noyanšiq abūritu tula Noyaqin obuytan boluba. (MHT§ 46)	Манж: noyan>ноён
26.	*Barula+s	-	Barulas obuytan	Qačiyu-yin kögün Barulatai neretü бүlege. Jeke beyetü, idegen-e baruq бүlege. Barulas obuytan boluba.	-
27.	*Barula Barula+s	-	Jeke-Barula, Üčügen-Barula Erdemtü-Barula, Tödögen-Barula	Qačula-in kögün idegen-e baruq tula Jeke-Barula, Üčügen-Barula nereyitcü, Barulas obuytan bolyažu, Erdemtü-Barula, Tödögen-Barula terigüten Barulas tede boluba.	-
28.	*Budaya+t	-	Budayat obuytan	Qaralday+yin kögüt budayan qutqulaqu eki terigü ükegün tula Budayat obuytan tede boluba.	-
29.	*Adar+yin	-	Adaryin obuytan	Qačiyun-nu kögün Adarqidai neretü бүlege Aqa degü žayura adaruqči tula Adaryin obuytan bolba.	-
30.	*Maŋqu+t	-	Maŋqut obuytan	Načın-Bayatur-un kögüt Uruıudai, Maŋqutai nereten бүlege. Maŋqut obuytan tede boluba.	Түрэг: маңгыт

31.	*Tayičiγu+t	-	Tayičiγu obuytan	Qaidu-yin kögün Bai-Šingqor-Doysin, Čaraqai-Linqu, Čažin-Örtegei qurban bülege. Bai-Šingqor-Doysin-u kögün Tumbinai-Sečen. Čaraqai-Linqu-yin kögün Sengün -Bilge. Ambayai-tan Tayičiγut obuytan boluba. (MHT§47)	-
32.	*Besü+t	-	Besüt obuytan	Čaraqai-Linqu -yin berigen eme-deče töreksen Besütei neretü bülege. Besüt obuytan tede boluba.	-
33.	*Oro+nar	-	Oronar obuytan	Čažin-Örtegei-jin kögüt Oronar, Qoŋqotan, Arulat, Sönit, Qab-Turqas, Geniges obuytan tede boluba.	-
34.	*Qoŋ+qotan	-	Qoŋqotan obuytan	?	-
35.	*Arula+t	-	Arulat obuytan	?	-
36.	*Sönit+t	-	Sönit obuytan	?	-
37.	*Qab-Turqas	-	Qab-Turqas obuytan	?	-
38.	*Geniges	-	Geniges obuytan	?	-
39.	*Jürki	-	Jürki obuytan	Ökin-Barqay-un kögün Qutuγtu-Jürki bülege. Qutuγtu-Jürki-jin kögüt Seče-beki, Tayču qoyar bülege. Jürki obuytan tede boluba (MHT§49)	Түрэг: үүрек> зүрх(зоригтой?)
40.	*Ayriγu+t	-	Ayriγut	?	-
41.	*Buyruγu+t	-	Buyruγut	1.«тушаалтангууд», 2. «ивээлтэй (?), хишигтэй»	Түрэг: Бууруγ> буюруг (тушаал, зарлиг?)
42.	*Olqunu+γud	-	Olqunuγud irkin	Olqunuγud irkin Olqunuγut irkin-tür Oŋγiradai Мон: Oŋγiradai – онгирадай.	Перс: qnqwrat qoŋγirad // qonggirad->«кунгират» «унгираты»
43.	*Qiyān > Qiya+t		Qiyat	Qiyat Мон: qiya+n >qiya+t >qiyat>кыйат.	Түрэг: qaya> кайа, 1.хад, 2.эгц ташуу хад

Хүснэгт 2. Монгол угсаатны зарим нэрийтгэл

Дүгнэлт

Түрэг, монгол угсаатны зарим нэрийтгэлийн үүсэл гарлыг мөшгөвөөс, үүнд: домог зүйн нэрс (мэргэн, билиг зэрэг), махчин анч шувуудын нэрс (ялангуяа: qut- >, qur- >, quu- >, quz- >, qar- >, qir- >, qon- >, ker- >, kir- > зэрэг язгууртай) (Базылхан, 2004: 5-7; Базылхан, 2013: 173-179), өнгө зүс, зүг чигийн заасан нэрс (хөх, хар, шар, улаан, цагаан, хойд, баруун, зүүн зэрэг), тооны нэр (2, 3, 8, 10, 20, 30, 40 зэрэг), гэр тэрэг, өндөр дугуйт гэр тэрэг, нум, нумчин, саадаг, хоромсоготон, мэргэн намнагч зэргийн нэрийтгэл болон адуу, мал морины нэрс, араатан чононы нэрсийг сэргээн тодруулсан бөгөөд энэ нь түрэг, монгол угсаатны овог, аймаг, холбоодын нэрийтгэлд олонтоо илэрч байгааг, басхүү зарим нэрийтгэл түүхийн удаан хугацааны туршид эртний хэлбэр бүтцээ хадгалан ирснийг, зарим бэлгэдэл утга зүйн умартагдан мартагдсаныг энд онцлох дурдах байнам. Тиймээс ч түрэг, монгол хэлнүүдийн түүхэн эх сурвалж, хэлний хэрэглэгдэхүүн басхүү гадаад харь хэлнүүдийн сурвалжид түшиглэн түрэг, монгол угсаатны нэрийтгэлийг сэргээн тодруулах, бэлгэдэл, утга зүйн учрыг олох бүрэн боломжтой билээ.

Энэхүү судалгааны цаашдын улам нарийвчилсан, олон талт судалгааны явцад түрэг, монгол угсаатны нэрийтгэлийн нийтлэг болоод онцгойрох хууль зарчмыг цуваа цагийн үүднээс харьцуулан гаргавал угсаатны нэрийтгэлийн эрт, эдүгээгийн иж бүрэн байдал хийгээд, угсаатны нүүдэл, суудлын болон харилцан холбоотой, уялдаатай явсан түүхэн үйл, чиг шугамыг, зам жимийг сэргээн харах ч (тодруулбал, тухайн нэгэн угсаатны нутаг, нүүдэл, суудлын түүхэн болон орчин цагийн газар зүйн зураг, байршил зэргийг тодруулах) бололцоо бүрдэх билээ.

Ном зүй

Базылхан, Н. (2004). Қыран құстың этносимболикасы: тарихи-этимологиялық шолу. «Рух-мирас» альманагы, I (1), X. 5-7. [Bazylkhan, N. (2004). Ethnosymbolism of the eagle bird: a historical and etymological review. "Rukh-miras" almanac. I (1), P. 5-7.]

Базылхан, Н. (2013). Хищные птицы в древнетюркской этносимболике (по этноархеологическим и источниковедческим материалам). *Культуры и народы Северной и Центральной Азии в контексте 90 междисциплинарного изучения: сборник Музея археологии и этнографии Сибири им. В.М. Флоринского*. Томск : Томский государственный университет. Вып. 3. С.173-179. [Bazylkhan, N. (2013). Birds of prey in ancient Turkic ethnosymbolism (based on ethnoarchaeological and source materials). *Cultures and peoples of Northern and Central Asia in the context of 90 interdisciplinary study: collection of the V.M. Florinsky Museum of Archaeology and Ethnography of Siberia*. Tomsk: Tomsk State University., Issue 3. P. 173-179.]

Баскаков, Н.А. (1980). Модели тюркских этнонимов и их типологическая классификация. *Ономастика Востока*. Москва. С.199-207. [Baskakov, N.A. (1980). Models of Turkic ethnonyms and their typological classification. *Onomastics of the East*. Moscow. P.199-207.]

Викторова, Л.Л. (1961). К вопросу о найманской теории происхождения монгольского литературного языка и письменности (XII-XIII вв.). Ученые записки ЛГУ. Серия востоковедческих наук. Вып.12., №305. С.137-155. [Viktorova, L.L. (1961). On the issue of the Naiman theory of the origin of the Mongolian literary language and writing (XII-XIII centuries). *Scientific notes of Leningrad State University. Oriental Studies Series*. Issue 12., No. 305. P.137-155]

Зуев, Ю.А. (1960). Тамги лошадей из вассальных княжеств (перевод из китайского сочинения VIII–X вв. *Танхуйяо*, т.III, цзюань 72, стр. 1305–1308. Труды ИИАЭ АН Казахской ССР. Новые материалы по древней и средневековой истории. Казахстана. Алма-Ата., Т. VIII. с.91–140.

Зуев, Ю.А. (1972). «Джами ат-таварих» Рашид ад-дина как источник по ранней истории Джалаиридов. *Письменные памятники Востока*. С.178-185. [Zuev, Yu.A. (1972). “Jami at-tavarikh” by Rashid ad-Din as a source on the early history of the Jalairs. *Written monuments of the East*. P. 178-185.]

Каратаев, О. (2003). *Кыргыз этнонимдер сөздүгү*. Бишкек., С. 247. [Karataev, O. (2003). *Dictionary of Kyrgyz ethnonyms*. Bishkek. P. 247.]

Кузеев, Р.Г. (1974). Происхождение башкирского народа. Этнический состав, история расселения. Москва: Наука. С. 177-184. [Kuzeev, R.G. (1974). *Origin of the Bashkir people. Ethnic composition, history of settlement*. Moscow: Science. P. 177-184]

Махпиров, В.У. (1997). *Имена далеких предков. Источники формирования и особенности функционирования древнетюркско ономастики*. Алматы: Институт Востоковедения МН-АН РК. С. 302. [Makhpiro, V.U. (1997). *Names of distant ancestors. Sources of formation and features of functioning of ancient Turkic onomastics*. Almaty: Institute of Oriental Studies MN-AN RK. P. 302.]

Мөнхтулга, Р. (2019). Тоньюкукийн гэрэлт хөшөөний бичээсийн äšir хэмээх нэрийн тухай. “Ази судлал” Олон улсын эрдэм шинжилгээний тавдугаар хурал. V. X.633-637. [Munkhtulga, R. (2019). About the name äšir in the Tonyukuk Inscription. “Asian Studies” Fifth International Scientific Conference. V. P. 633-637.]

Очир Т., Сэржээ Б. (1998). *Монголчуудын овгийн лавлах*. Улаанбаатар: ШУА-ийн Информатикийн хүрээлэнгийн хэвлэх үйлдвэр. X.11.[Ochir T., Serjee

В. (1998). *Directory of Mongols*. Ulaanbaatar: Printing plant of the Informatics Institute of MAS. P. 11.]

Очир, А. (2016). Монгольские этнонимы: вопросы происхождения и этнического состава монгольских народов. Элиста: КИГИ РАН, С. 286. [Ochir, A. (2016). Mongolian Ethnonyms: Issues of Origin and Ethnic Composition of Mongolian Peoples. Elista: KIGI RAS. P. 286.]


Пэрлээ, Х. (1976). *Монгол түмний гарлыг тамгаар хайж судлах нь*. Улаанбаатар: ШУА-ийн Хэвлэх үйлдвэр. Х.230. [Perlee, H. (1976). Studying the origins of the Mongolian people through seals. Ulaanbaatar: MAS Printing Plant. P. 230.]

Султанов, Т.И. (1977). Опыт анализа традиционных списков 92 «Племен Илатийа». *Средней Азия в древности и средневековье*. С.165-175. [Sultanov, T.I. (1977). An attempt to analyze traditional lists of 92 "Ilatiya Tribes". *Central Asia in Antiquity and the Middle Ages*. P. 165-175.]

Юдин, В.П. (2001). *К этимологии этнонима казах (қазақ) Центральная Азия в XIV-XVIII веках глазами востоковеда*. Алматы: Дайк-Пресс. IV. С.137-166. [Yudin, V.P. (2001). On the Etymology of the Ethnonym Kazakh (Kazakh) Central Asia in the 14th-18th Centuries through the Eyes of an Orientalist. Almaty: Daik-Press. IV. P.137-166.]

Clauson, G. (1963). The Name Uyгур. *JRAS*. III-IV, P.140-149.

Murayama, S. (1959). Sind die Naiman Turken oder Mongolen?. *Central Asiatic Journal*. III. P.188-198.



Open access: This is an open access article distributed in accordance with the Creative Commons Attribution Non-Commercial (CC BY-NC 4.0) license, which permits others to distribute, remix, build upon this work non-commercially, and license their derivative works on different terms, provided the original work is properly cited, appropriate credit is given, any changes made indicated, and the use is non-commercial. See: <http://creativecommons.org/licenses/by-nc/4.0/>.